



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 62

Сүхбаатар сум


Сэлэнгэ аймгийн 2019 оны төсөв батлах тухай 51 дүгээр тогтоолын хавсралт дахь зарим төсөл, арга хэмжээний нэршил өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “б”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.4, 42 дугаар зүйлийн 42.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Сэлэнгэ аймгийн 2019 оны төсөв батлах тухай” 51 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт дахь “Аймгийн төсвийн хөрөнгөөр 2019 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын 2.2.1 дэх арга хэмжээний нэршлийг хавсралтад зааснаар өөрчилсүгэй.

Хоёр.Шинэчлэн баталсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг аймгийн Засаг дарга /Ш.Оргил/-д даалгасугай.

ДАРГА  Г.БЯМБАА



**Аймгийн төсвийн хөрөнгөөр 2019 оны төсвийн жилд
хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний
нэршил өөрчлөгдсөн барилга байгууламжийн жагсаалт**

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Эхлэх, дуусах хугацаа	Нийт төсөвт өртөг /мян.төг/	2019 онд санхүүжүүлэх дүн /мян.төг/
2.2.1	Сайхан суманд төрийн албан хаагчийн орон сууц худалдан авах	2019-2019	110'000.0	110'000.0

оОо